



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХӨДӨӨ АЖ АХУЙН  
САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА  
2022



2023 он



## Гарчиг

### Оршил

Мал тооллогын товч түүх

Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт

1. Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт
2. Малтай өрх болон малчин өрх, малчдын тоо, тэдний ахуйн зарим үзүүлэлт
  - 2.1. Малтай өрх, малчин өрх
  - 2.2. Малтай өрхийн бүлэглэлт
  - 2.3. Малчдын мэдээлэл
  - 2.4. Малчдын нийгэм, соёлын зарим үзүүлэлт
3. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн
  - 3.1. Малын тоо, бүтэц
  - 3.2. Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо
  - 3.3. Төл бойжилт
  - 3.4. Том малын зүй бус хорогдол
  - 3.5. Малын хээл хаялт, сувайралт
  - 3.6. Малын хэрэглээний зарлага
  - 3.7. Сүргийн бүтэц
  - 3.8. Тэжээвэр амьтад
4. Малжуулалт, шинээр гаргасан худгийн тайлан
  - 4.1. Малжуулалтын талаар авсан арга хэмжээний тайлан
  - 4.2. Шинээр гаргасан, засварласан худгийн мэдээлэл
5. Газар тариалан
6. Улсын дүн бүхий хавсралт хүснэгт

### Дүгнэлт

Мэдээллийн эх үүсвэр



## Оршил

Дундговь аймгийн эдийн засгийн суурь голлох салбар бол хөдөө аж ахуй тэр дундаа мал аж ахуйн салбар юм.

Манай улс үндсэн хуулиндаа мал сүргийг үндэсний баялаг хэмээн зааж, мал тэжээвэр амьтдын тооллогыг жил бүр зохион байгуулан, үр дүнг үндэсний хэмжээнд тооцон бодлого төлөвлөлтөнд ашиглаж байна.

Монгол улсын “Статистикийн тухай” хуулийн 7-р зүйлийн 1 дэх заалтийн дагуу мал тэжээвэр амьтдын тооллогыг жил бүрийн 12 сарын 7-ноос 17-ны хооронд орон даяар зохион байгуулдаг.

Сүүлийн 5 жилийн мал, тэжээвэр амьтдын тооллогын онцлог нь малчдын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулдаг болсон юм. Энэ нь Монгол улсын төрөөс явуулж буй малчдын тэтгэвэрт гарах насыг 5 жилээр наашлуулах болон малчдыг нийгмийн даатгалд хамруулах бодлоготой уялдсан юм.

Энэхүү танилцуулгад 2022 оны мал, тэжээвэр амьтдын тооллогын дэлгэрэнгүй үр дүн болон газар тариалангийн салбарын тухайн оны төлөв байдлыг нэгтгэн тусгахыг зорьлоо. Манай аймгийн хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбар нь газар зүйн байрлал, онцлог шинжээс шалтгаалан байгаль цаг уураас шууд хамааралтай бөгөөд мал аж ахуйн хувьд бэлчээрийн мал аж ахуй голлож байна.

Танилцуулгад малын тооны өсөлт өөрчлөлт, бүтэц, мал төллөлт, үржлийн байдал, зүй бус хорогдол, хээл хаялт, хээлтэгч, хээлтүүлэгч, түүний тохироо болон малтай өрх, малчин өрх, малчдын нийгмийн байдал, малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд зэрэг мал аж ахуй, хөдөө аж ахуйтай холбоотой бүхий л Статистик мэдээлэл, үзүүлэлтүүдийг хамрууллаа.

Ингэснээр манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийх, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, салбарын ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, төлөвлөхөд суурь мэдээлэл болно гэдэгт итгэж байна.



## МАЛ ТООЛЛОГЫН ТОВЧ ТҮҮХ

Мал аж ахуй нь Монгол орны хувьд амьжиргааны гол эх үүсвэр болсон анхдагч үйлдвэрлэлийн салбар байсны хувьд бүртгэл, статистикийн ажил ч энэ салбараас эхлэн хөгжсөн түүхтэй.

XIII зууны үед Монгол улсад хүн, малын тооллого явуулж байсан баримт түүхийн сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Манжийн хараат байх үед Монголд мал тооллого явуулж байсан боловч нэгдсэн тооллого хийж чаддаггүй, орон нутгийн чанартай байв. Аймаг, хошуудад янз бүрийн хугацаанд, өөр өөрсдийн шаардлага үзэмжээр мал тооллого явуулж байсан байна.

Гадаад Монголын Засгийн газар 1918 онд хүн ам, малын тооллого явуулсан байна. Уг тооллого нь халхын 4 аймаг, лам, ноёд, шавь албат ардууд, сүм хийдийн малыг хамруулсан боловч Ховдын хязгаар, Дархадын хязгаар, Хөвсгөл нуур орчмын Богд гэгээний эзэмшил нутгийн мал ороогүй ажээ.

Ардын засгийн газар 1924 онд Дотоод яамны бүтцэд Тоо бүртгэлийн хэлтсийг шинээр байгуулж, мал тооллогыг үнэн зөв явуулах талаар онцгой анхаарч, тооллого явуулах, данс бүртгэлийг нэгтгэх, тушаах цаг хугацааг тогтоож, хуучин төлөөний түшмэл дээр боловсрол чадвартай тусгай түшмэлийг нэмэн томилж, ард олонд тайлбарлан таниулах ажлыг зохиосны үр дүнд анх удаа улсын хэмжээгээр хугацаа, аргачлалын хувьд нэгдсэн программтай мал тооллого явагдсан байдаг. Мал тооллогод урьд өмнө нь бүртгэгдэхгүй байсан цаа буга, илжиг, луус, өвс хадлан, тариалангийн талаар зарим нэмэлт үзүүлэлтийг 1924 оноос эхлэн оруулсан байна. Мал тооллогыг зун, намрын улиралд буюу ихэвчлэн 8, 9 дүгээр сард явуулж байсан бол 1961 оноос мал, тэжээвэр амьтдыг жилийн эцэст 12 дугаар сард тоолдог болсон. Энэ хугацаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын орлого, зарлагын үзүүлэлт бүрэн гарч дууссан, малчид өвөлжөөндөө бууж, хүн, малын хөдөлгөөн харьцангуй бага байдаг зэрэг давуу талтай юм.

Малын хашаа байрын тооллогыг 1966 оноос, худаг, малын тэжээлийн тооллогыг 1972 оноос нэмж мал тооллоготой хамтруулан явуулдаг болов. Ардын хувийн аж ахуйтны малыг 1959-1960 онд нийгэмчилж, хоршоололд хамруулж дууссан бол 1992 онд малыг хувьчлах ажил хийгдэж дууссан билээ.



## НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

**Малчин өрх:** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх.

**Малтай өрх:** Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх.

**Малчид:** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

### **Бодод шилжүүлэх коэффициент:**

1 адуу, үхэр -1 бод	6 хонь - 1 бод
1 тэмээ - 1.5 бод	8 ямаа - 1 бод

### **Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:**

1 тэмээ- 5 хонь	1 хонь - 1 хонь	
1 адуу - 7 хонь	1 ямаа - 0.9 хонь	1 үхэр- 6 хонь

**Нас гүйцсэн мал:** Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

### **Өсвөр насны мал:**

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал, Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч:** Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хамруулна.

**Малын тоо, толгойн өсөлт:** Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцуулсан үзүүлэлтийг оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

**Төллөлтийн хувь:** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан 100 -гаар үржүүлнэ.

**Бойжилтийн хувь:** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**100 эхээс бойжуулсан төл:** Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо:** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур – 20-25	Бух – 35-45
Азарга- 12-15	Хуц, Ухна - 25-30

**Малын зүй бус хорогдолд** өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

**Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь:** Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.



**Малын хэрэглээний зарлага:** Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бусын хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

**Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент:** Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

- Хадлан өвс - 0.45
- Таримал тэжээл - 0.35
- Даршны ургамал - 0.25
- Гар тэжээл, хужир шүү - 1.0
- Төмс ногооны хаягдал - 0.22
- Үр тарианы хаягдал - 0.9
- Лай - 0.4

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

**Малын тэжээлийн ангилал:** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

• Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
3. Шүүст тэжээл- Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
  - Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
  - Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

**Тариалангийн талбай** гэж хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжөөсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

**Тариалсан талбай** гэж тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээ юм.

**Хураасан талбай** гэж тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээ юм.

**Га-гийн ургац** гэж талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамлын тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тэр талбайн нийт хэмжээнд харьцуулж тодорхойлно. /1тн=10 цн=1000кг /

**Нийт ургац нь** тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

**Эдийн засгийн бүсэд:**

- Баруун бүс - Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан
- Хангайн бүс - Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг
- Төвийн бүс - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг
- Зүүн бүс - Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг
- Улаанбаатар бүс - Улаанбаатар хот




## 1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

### I.1 Мал аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх байр суурь

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2021 оны байдлаар 337.0 тэрбум төгрөг болж, аймгийн ДНБ-ий 56.3 хувийг эзэлж өмнөх оноос 3.4 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1. ДНБ-Д ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



### I.2. Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлт

2022 онд 7202.4 тн өвс хадлан, 3256 тн гар тэжээл, 1413.7 тн хужир шүү бэлтгэсэн байна. Өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 50.9 хувиар өсч, гар тэжээл 21.6 хувиар, хужир шүү 42.8 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

ХҮСНЭГТ 2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

	2017	2018	2019	2020	2021	2022	2022/ 2021
Өвс, хадлан, тн	1,143.1	1,766.6	7,344.9	12,426.	4773.3	7202.4	150.9
Гар тэжээл, тн	7,070.2	6,826.6	3,624.6	1,005.2	4153.1	3256.0	78.4
Хужир, шүү, тн	2,055.51	2,394.6	2,338.5	107.5	2471.1	1413.7	57.2
Тариалсан талбай, га	91.8	33.7	36.5	52.4	35.5	50.1	141.1
Хураан авсан ургац, тн	246.3	188.2	298.7	374.4	320.6	410.6	128.1



## 2. МАЛТАЙ ӨРХ БОЛОН МАЛЧИН ӨРХ, ТЭДНИЙ АХУЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

### 2.1. Малчин өрх, малтай өрх

Дундговь аймагт 2022 оны жилийн эцэст нийт 14892 өрхийн 47199 хүн ам амьдарч байна. Өмнөх оноос 0.3 хувь ба 45 өрхөөр өсч, 0.7 хувь буюу 343 хүнээр буурсан.

Хүснэгт 2. Өрх, хүн ам тоо, байршлаар


Сумд	Өрх	Бүгд хүн ам	Эрэгтэй	Эмэгтэй	Хөдөөд	ХБИ
Адаацаг	778	2746	1408	1338	2245	106
Баянжаргалан	451	1290	688	602	734	26
Говь-Угтаал	475	1458	768	690	1036	86
Гурвансайхан	695	2124	1088	1036	1775	72
Дэлгэрхангай	696	2225	1153	1072	1236	118
Дэлгэрцогт	560	1573	835	738	1092	56
Дэрэн	640	2138	1089	1049	1638	64
Луус	605	1865	987	878	1207	98
Өлзийт	809	2274	1267	1007	1907	94
Өндөршил	470	1434	710	724	1083	49
Сайнцагаан	5185	16792	7959	8833	3354	781
Сайхан-Овоо	678	2131	1110	1021	1444	72
Хулд	772	2305	1195	1110	1471	70
Цагаандэлгэр	366	995	527	468	508	26
Эрдэнэдалай	1712	5849	2933	2916	4619	196
	14892	47199	23717	23482	25349	1914

2022 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор 8930 малтай өрх тоологдсон ба үүнээс 7682 өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг малчин өрх байна. Малчин өрхийг сумдаар авч үзвэл Өндөршил суманд 2, Луус суманд 6, Говь-Угтаал суманд 6, Гурвансайхан суманд 12, Дэрэн суманд 13, Хулд суманд 22, Сайнцагаан суманд 35 өрхөөр өмнөх оноос өссөн бол бусад сумдад 2-20 өрхөөр буурсан үзүүлэлттэй байна.





Зураг. 2. Малчин өрх, малчдын тоо, 2022 оны жилийн эцэст



Аймгийн нийт өрхийн 51.6 хувийг малчин өрх эзэлж байна. Малтай болон малчин өрхийн тоог өмнөх онтой харьцуулахад малтай өрх 0.1 хувиар буурч, малчин өрх 0.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Малчин өрх, малтай өрхийн тоо, жил бүрийн эцэст

Сумдын нэр	Малтай өрхийн тоо					Малчин өрхийн тоо				
	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
ДҮН	8466	8593	8967	8942	8930	7159	7248	7596	7670	7682
Сайнцагаан	1006	1016	1084	1084	1120	856	831	883	893	928
Адаацаг	636	643	659	658	653	531	539	556	554	549
Баянжаргалан	287	295	300	295	284	229	234	249	255	249
Говь-Угтаал	367	357	369	371	368	272	279	282	283	289
Гурвансайхан	514	536	560	558	568	432	495	508	507	519
Дэлгэрхангай	576	582	611	594	581	396	406	453	452	433
Дэлгэрцогт	435	435	444	441	426	384	384	390	391	375
Дэрэн	497	497	512	521	533	432	428	445	453	466
Луус	407	418	447	453	450	360	362	363	392	398
Өлзийт	630	654	700	706	713	573	585	635	646	644
Өндөршил	346	360	376	371	357	275	269	292	292	294
Сайхан-Овоо	506	509	518	516	520	416	402	410	437	430
Хулд	572	582	601	614	624	458	477	512	517	539
Цагаандэлгэр	302	315	324	315	314	263	273	272	270	261
Эрдэнэдалай	1385	1394	1462	1445	1419	1282	1284	1346	1328	1308

**2.2. Малтай өрхийн малын бүлэглэлт**




2022 оны иргэдийн малын бүлэглэлтээс авч үзвэл нийт малчин өрхийн 16.3 хувь нь 100 хүртэл малтай, 19.6 хувь нь 101-200 малтай, 36.7 хувь нь 201-500 малтай, 19.3 хувь нь 501-99 малтай, 8.2 хувь нь 1000-аас дээш малтай байна.

Хүснэгт.4. Малчин өрхийн бүлэглэлт

Бүлэглэлт	Малчин өрх					Дүнд эзлэх хувь				
	2018	2019	2020	2021	2022	2018	2019	2020	2021	2022
<b>ДҮН</b>	7159	7248	7598	7670	7682	100	100	100	100	100
<b>30 хүртэл малтай</b>	132	114	175	262	188	1.8	1.6	2.3	3.4	2.5
<b>31-50</b>	157	142	200	290	239	2.2	2	2.6	3.8	3.1
<b>51-100</b>	457	386	524	695	574	6.4	5.3	6.9	9.1	7.5
<b>101-200</b>	1006	949	1216	1505	1337	14.1	13.1	16	19.6	17.4
<b>201-500</b>	2599	2628	2778	2812	2738	36.3	36.3	36.6	36.7	35.6
<b>501-999</b>	1904	2032	1874	1484	1813	26.6	28	24.6	19.3	23.6
<b>1000-1499</b>	678	745	666	523	640	9.5	10.3	8.8	6.8	8.3
<b>1500-2000</b>	158	176	115	75	119	2.2	2.4	1.5	1	1.6
<b>2001-ээс дээш</b>	68	76	50	24	34	0.9	1	0.7	0.3	0.4

Иргэдийн малын тооны бүлэглэлтээс харвал нийт өрхөд эзлэх тухайн бүлгийн хувь өмнөх оноос 30 хүртэл малтай малчин өрх 0.9 хувиар, 31-50 хүртэл малтай малчин өрх 0.7 хувиар, 51-100 малтай малчин өрх 1.6 хувиар, 101-200 хүртэл малтай малчин өрх 2.2 хувиар, 201-500 малтай малчин өрх 1.1 хувиар тус тус буурч, 501-999 малтай малчин өрх 4.3 хувиар, 1000-1499 малтай малчин өрх 1.5 хувиар, 1500-2000 малтай малчин өрх 0.6 хувиар, 2001-ээс дээш малтай малчин өрхийн эзлэх хувь 0.1 хувиар тус тус өссөн байна. Энэ жилийн хувьд мал тоо толгой өсч, үүнтэй холбоотой 500-с дээш малтай өрхийн тоо өссөн байна

Зураг 3. Малтай өрхийн бүлэглэлт



Хүснэгт.5. Малчин өрхийн бүлэглэлт, сумаар, 2022 оны жилийн эцсийн байдлаар



Сумд	Малчин өрхийн бүлэглэлт									
	Бүгд	30 хүртэл малтай	31-50 малтай	51-100 малтай	101-200 малтай	201-500 малтай	501-999 малтай	1000-1499 малтай	1500-2000 малтай	2001-аас дээш малтай
Сайнцагаан	928	15	37	95	186	368	171	40	12	4
Адаацаг	549	7	7	40	92	221	103	72	6	1
Баянжаргалан	249	7	10	24	43	66	57	34	7	1
Говь-Угтаал	289	3	8	20	38	80	97	29	11	3
Гурвансайхан	519	19	17	34	86	165	137	55	4	2
Дэлгэрхангай	433	8	15	33	84	181	84	22	4	2
Дэлгэрцогт	375	9	11	35	65	135	76	29	9	6
Дэрэн	466	10	12	25	70	151	137	46	9	6
Луус	398	7	6	17	70	156	115	24	1	2
Өлзийт	644	7	24	51	102	201	181	60	17	1
Өндөршил	294	8	6	20	45	94	64	47	10	0
Сайхановоо	430	8	10	25	80	184	102	19	1	1
Хулд	539	4	8	27	85	199	171	36	8	1
Цагаандэлгэр	261	6	4	16	43	92	58	37	5	0
Эрдэнэдалай	1308	70	64	112	248	445	260	90	15	4
<b>Нийт</b>	<b>7682</b>	<b>188</b>	<b>239</b>	<b>574</b>	<b>1337</b>	<b>2738</b>	<b>1813</b>	<b>640</b>	<b>119</b>	<b>34</b>

2022 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр нэг малчин өрхөд ногдох малын тоо /толгойн тоогоор/ 451 мал байгаа нь өмнөх оноос 57 толгой малаар өссөн үзүүлэлт байна.

Хүснэгт 6. Малтай өрхийн тоо, малын бүлэглэлт жил бүрийн эцэст

Бүлэглэлт	Малтай өрхийн тоо					Нийт дүнд эзлэх хувь				
	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Бүгд	8466	8593	8967	8942	8930	100	100	100	100	100
10 хүртэлх	42	40	55	91	60	0.5	0.5	0.6	1.0	0.7
11-30	236	206	301	426	322	2.8	2.4	3.4	4.8	3.6
31-50	315	297	373	496	404	3.7	3.5	4.2	5.5	4.5
51-100	767	691	866	1001	904	9.1	8	9.7	11.2	10.1
101-200	1403	1350	1620	1818	1664	16.6	15.7	18.1	20.3	18.6
201-500	2853	2933	3021	2983	2950	33.7	34.1	33.7	33.4	33.0
501-999	1944	2076	1898	1503	1830	23	24.2	21.2	16.8	20.5
1000-1499	679	748	668	523	640	8	8.7	7.4	5.8	7.2
1500-2000	159	176	115	76	121	1.9	2	1.3	0.8	1.4
2001-с дээш	68	76	50	25	35	0.8	0.9	0.6	0.3	0.4

Малтай өрхийг малын тоогоор бүлэглэн, нийт малтай өрхөд эзлэх хувиар авч үзвэл 30 хүртэлх малтай өрх 1.5 хувиар, 51-200 хүртэлх малтай өрх 3.7 хувиар, 51-500



малтай өрх 2.8 хувиар буурч, 31-50 хүртэлх малтай өрх 1.0 хувиар, 501-999 малтай өрх 3.7 хувиар, 1000-аас дээш малтай өрх 2.1 хувиар өссөн байна.


Хүснэгт.7. Өрх, ам бүлд ногдох мал, сумаар,

Сумд	Малтай өрх					Малчин өрх					Малтай нэг өрхөд ногдох мал (толгой)	Малчин нэг өрхөд ногдох мал (толгой)
	2018	2019	2020	2021	2022	2018	2019	2020	2021	2022		
Сайнцагаан	1006	1016	1084	1084	1120	856	831	883	893	928	302	379
Адаацаг	636	643	659	658	653	531	539	556	554	549	384	475
Баянжаргалан	287	295	300	295	284	229	234	249	255	249	394	496
Говь-Угтаал	367	357	369	371	368	272	279	282	283	289	428	574
Гурвансайхан	514	536	560	558	568	432	495	508	507	519	408	476
Дэлгэрхангай	576	582	611	594	581	396	406	453	452	433	259	387
Дэлгэрцогт	435	435	444	441	426	384	384	390	391	375	321	456
Дэрэн	497	497	512	521	533	432	428	445	453	466	407	524
Луус	407	418	447	453	450	360	362	363	392	398	343	446
Өлзийт	630	654	700	706	713	573	585	637	646	644	415	498
Өндөршил	346	360	376	371	357	275	269	292	292	294	445	542
Сайхановоо	506	509	518	516	520	416	402	410	437	430	286	394
Хулд	572	582	601	614	624	458	477	512	517	539	388	483
Цагаандэлгэр	302	315	324	315	314	263	273	272	270	261	401	505
Эрдэнэдалай	1385	1394	1462	1445	1419	1282	1284	1346	1328	1308	312	390
Дүн	8466	8593	8967	8942	8930	7159	7248	7598	7670	7682	354	451

Мянгаас дээш малтай малчин өрхийн тоо энэ онд 793 болж, өмнөх оноос 169 өрхөөр буюу 27.1 хувиар өссөн байна. Хамгийн олон мянгат малчинтай сумдаар, Эрдэнэдалай сум 109 мянгат өрх, Адаацаг сум 79 мянгат малчин өрх, Өлзийт сум 78 мянгат өрх, Гурвансайхан сум 61 мянгат өрх, Дэрэн сум 61 мянгат өрх, Өндөршил сум 57 мянгат өрх, Сайнцагаан сум 56 мянгат өрхтэй байна.



Зураг 4. 1000 дээш малтай өрхийн тоо сумдаар (2021-2022 он)



### 2.3 Малчдын мэдээлэл

2022 онд мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа малчдын тоо 12446 болж өмнөх оноос 0.7 хувь буюу 90 хүнээр буурсан байна. Аймгийн нийт иргэдийн 26.4 хувийг малчид эзэлж байна. Нийт малчдын 41.9 хувь буюу 5218 эмэгтэй, 58.1 хувь буюу 7228 эрэгтэй байна. Малчдыг насны бүлгээр авч үзвэл 25.1 хувь нь 15-34 нас, 61.1 хувь нь 35-59 нас, 13.8 хувь нь 60-аас дээш насны тэтгэврийн хүмүүс байна. Нийт малчдын 1.9 хувь буюу 241 нь туслах малчин байна

Хүснэгт 8. Малтай өрх, малчин өрх, малчдын мэдээлэл, онуудаар

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2022/ 2021
Малтай өрх	7503	7947	8283	8466	8593	8697	8942	8930	99.9
Малчин өрх	6181	6590	7001	7159	7248	7598	7670	7682	100.2
Малчдын тоо	11633	12171	12222	12136	12241	12505	12536	12446	99.3
Үүнээс: 15-34 насны	3868	3948	4021	3870	3669	3520	3259	3118	95.7
35-59 насны	6426	6748	6772	6865	7107	6997	7593	7607	100.2
60+	1339	1475	1429	1401	1465	1988	1684	1721	102.2
Нийт малчидаас эмэгтэй	5274	5485	5361	5210	5210	5254	5265	5218	99.1
Нэг малчин өрхөд ногдох малын тоо	447	464	513	534	564	467	394	451	114.5



Зураг 5. Үндсэн болон туслах малчдын тоо (5 жилээр)




Малчдыг насны бүлгээр өмнөх онтой харьцуулж үзэхэд 35-60 насны малчид 3.9 хувиар өсч, 15-34 насны малчид 0.9 хувиар, 60-с дээш буюу тэтгэврийн насны малчид 3.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9. Малчдын тоо (10 жилээр)

Сумд	Нийт малчдын тоо									
	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Сайнцагаан	1156	1245	1294	1362	1401	1371	1375	1423	1423	1413
Адаацаг	973	960	944	993	966	940	962	932	919	927
Баянжаргалан	322	337	330	326	380	365	369	399	393	378
Говь-Угтаал	445	493	509	507	512	482	489	483	477	488
Гурвансайхан	736	725	737	773	776	764	808	831	805	829
Дэлгэрхангай	597	628	631	672	714	687	700	749	730	694
Дэлгэрцогт	541	547	572	600	623	610	609	584	578	549
Дэрэн	746	764	783	806	758	799	793	836	835	834
Луус	598	586	631	638	651	672	640	663	695	702
Өлзийт	788	792	823	873	904	960	984	1030	1018	995
Өндөршил	386	387	404	420	414	440	432	467	473	473
Сайхан-Овоо	601	635	694	769	742	713	706	705	731	729
Хулд	663	671	783	839	767	775	811	833	820	841
Цагаандэлгэр	348	369	395	387	384	392	406	404	398	378
Эрдэнэдалай	2038	2075	2103	2206	2230	2166	2157	2166	2241	2216
<b>Дүн</b>	<b>10938</b>	<b>11214</b>	<b>11633</b>	<b>12171</b>	<b>12222</b>	<b>12136</b>	<b>12241</b>	<b>12505</b>	<b>12536</b>	<b>12446</b>

Зураг 6. Малчдын насны бүтэц, хувиар, онуудаар



Малчдын насны бүтцийг сумдаар авч үзвэл 15-34 насны залуучууд Өндөршил, Дэрэн, Баянжаргалан, Дэлгэрхангай сумдууд 27.4-28.3 хувийг, 35-59 насны идэрчүүд Сайхан-Овоо, Гурвансайхан, Говь-Угтаал сумдууд 63.9-64.9 хувийг, тэтгэврийн насныхан Цагаандэлгэр, Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэрэн сумдууд 16.4-20.6 хувийг тус тус эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Малчдын хүйсийн харьцааг авч үзвэл аймгийн хэмжээнд 100 эмэгтэй малчинд 139 эрэгтэй малчин ноогдож байгаа нь хүйсийн харьцаа хөдөөд алдагдаж байгааг харуулж байна.

Хүснэгт 10. Малчдын тоо, насны бүлгээр, 2022 оны жилийн эцсийн байдлаар

Сумд	Нийт малчдын тоо	Насны бүлэг			Хувиар			Нийт малчдаас эрэгтэй	Нийт малчдаас эмэгтэй	Малчдын хүйсийн харьцаа
		15-34	35-59	60+	15-34	35-59	60+			
Сайнцагаан	1413	317	863	233	22.4	61.1	16.5	820	593	138
Адаацаг	927	254	575	98	27.4	62.0	10.6	531	396	134
Баянжаргалан	378	83	235	60	22.0	62.2	15.9	221	157	141
Говь-Угтаал	488	99	312	77	20.3	63.9	15.8	273	215	127
Гурвансайхан	829	184	534	111	22.2	64.4	13.4	475	354	134
Дэлгэрхангай	694	190	441	63	27.4	63.5	9.1	410	284	144
Дэлгэрцогт	549	130	329	90	23.7	59.9	16.4	333	216	154
Дэрэн	834	230	467	137	27.6	56.0	16.4	486	348	140
Луус	702	186	413	103	26.5	58.8	14.7	415	287	145
Өлзийт	995	271	592	132	27.2	59.5	13.3	590	405	146
Өндөршил	473	134	285	54	28.3	60.3	11.4	273	200	137
Сайхан-Овоо	729	188	473	68	25.8	64.9	9.3	435	294	148
Хулд	841	215	515	111	25.6	61.2	13.2	515	326	158
Цагаандэлгэр	378	68	232	78	18.0	61.4	20.6	228	150	152
Эрдэнэдалай	2216	569	1341	306	25.7	60.5	13.8	1223	993	123
<b>Бүгд</b>	<b>12446</b>	<b>3118</b>	<b>7607</b>	<b>1721</b>	<b>25.1</b>	<b>61.1</b>	<b>13.8</b>	<b>7228</b>	<b>5218</b>	<b>139</b>


#### 2.4. Малчдын нийгэм соёлын зарим үзүүлэлт

2022 оны байдлаар нийт малчдын 8796 буюу 70.7 хувь нь гэрлэлтээ батлуулсан, 1008 буюу 8.1 хувь нь батлуулаагүй байна. Харин 1733 малчин буюу 13.9 хувь нь




огт гэрлээгүй, 174 малчин буюу 1 хувь нь тусгаарласан, 148 малчин буюу 1 хувь нь цуцалсан, 587 буюу 4.7 хувь нь бэлэвсэн байна.

Зураг.7 Малчдын гэрлэлтийн байдал



Малчдын боловсролын түвшинг 2022 оны байдлаар авч үзэхэд 5340 малчин буюу 42.9 хувь нь суурь, 3152 малчин буюу 25.3 хувь нь бага, 2185 малчин буюу 17.6 хувь нь бүрэн дунд, 505 малчин буюу 4.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 354 малчин буюу 2.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой байгаа бол 350 буюу 2.8 хувь нь боловсролгүй, 560 малчин буюу 4.5 хувь нь дээд боловсролтой байна.

Зураг.8 Малчдын боловсролын түвшин



2022 оны байдлаар нийт малчдын 57.7 хувь буюу 7176 малчин зээлтэй байна. Мөн малчдын 59.9 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бол 39.7 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байна.





Хүснэгт 11. Малчдын нийгмийн зарим үзүүлэлтүүд-2022

Сумд	Зээлтэй малчин	Нийт малчдад эзлэх хувь	ЭМД-д хамрагддаг малчин	Нийт малчдад эзлэх хувь	НД-д хамрагддаг малчин	Нийт малчдад эзлэх хувь
Сайнцагаан	809	57.3	983	69.6	600	42.5
Адаацаг	647	69.8	604	65.2	296	31.9
Баянжаргалан	272	72.0	285	75.4	187	49.5
Говь-Угтаал	239	49.0	324	66.4	275	56.4
Гурвансайхан	494	59.6	384	46.3	247	29.8
Дэлгэрхангай	460	66.3	417	60.1	306	44.1
Дэлгэрцогт	305	55.6	399	72.7	298	54.3
Дэрэн	578	69.3	393	47.1	178	21.3
Луус	324	46.2	313	44.6	270	38.5
Өлзийт	610	61.3	484	48.6	237	23.8
Өндөршил	206	43.6	272	57.5	252	53.3
Сайхан-Овоо	508	69.7	471	64.6	236	32.4
Хулд	429	51.0	414	49.2	393	46.7
Цагаандэлгэр	217	57.4	262	69.3	199	52.6
Эрдэнэдалай	1078	48.6	1453	65.6	964	43.5
<b>Нийт дүн</b>	<b>7176</b>	<b>57.7</b>	<b>7458</b>	<b>59.9</b>	<b>4938</b>	<b>39.7</b>


2022 оны мал тооллогын дүнгээр аймгийн нийт малчин өрхийн 83.4 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 79.1 хувь нь телевизортой, 60.6 хувь нь автомашинтай, 57.1 хувь нь мотоциклтой, 97.9 хувь нь гар утас хэрэглэдэг гэсэн үзүүлэлттэй гарсан байна.

Хүснэгт 12. Малчдын ахуй соёлын зарим үзүүлэлтүүд-2022

Үзүүлэлт	Өрхийн тоо					Малчин өрхөд эзлэх хувь					2022/ 2021
	2018	2019	2020	2021	2022	2018	2019	2020	2021	2022	
Малчин өрх	7159	7248	7598	7670	7682	-	-	-	-	-	-
Цахилгаантай	5370	5722	5998	6384	6407	75	78.9	78.9	83.2	83.4	0.2
Телевизортой	4906	5349	5642	6071	6080	68.5	73.8	74.2	79.2	79.1	-0.1
Автомашинтай	3458	3856	4282	4345	4653	48.3	53.2	56.4	56.6	60.6	4
Мотоциклтой	3917	4083	3897	3746	4384	54.7	56.3	51.3	48.8	57.1	8.3
Гар утастай	7159	7248	7318	7504	7523	100	100	96.3	97.8	97.9	0.1

Нийт өрхийн дүнд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулбал телевизортой өрх 0.1 хувиар буурч, цахилгаантай өрх 0.2 хувиар, автомашинтай өрх 4 хувиар, мотоциклтой өрх 8.3 хувиар, гар утастай өрх 0.1 хувиар тус тус өссөн байна.

Зураг.9 Малчдын ахуй соёлын зарим үзүүлэлт, сүүлийн 5 жилээр



### 3. МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, БҮТЭЦ

#### 3.1. Малын тоо, бүтэц


Дундговь аймаг 2022 оны жилийн эцэст 3626.4 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оноос 456 мянган толгой буюу 14.4 хувиар өссөн байна. Үүний дотор тэмээ 1766 толгой буюу 4.3 хувиар, адуу 24350 толгой буюу 15.5 хувь, үхэр 8809 толгой буюу 13.4 хувь, хонь 190826 толгой буюу 12.4 хувь, ямаа 230135 толгой буюу 16.8 хувиар өссөн байна. Нийт мал сүргийн 1.1 хувь нь буюу 41138 тэмээ, 2.1 хувь нь буюу 74535 үхэр, 5 хувь нь буюу 183067 адуу, 44.2 хувь буюу 1603415 ямаа, 47.6 хувь буюу 1724215 мянга нь хонин сүрэг байна. Тэмээний тоогоор 21 аймгаас 5-р байрт орсон байна.

Зураг 10 Малын тоо сая толгой 1942-2022





Зураг.11 Сумдын малын тоо




Аймгийн хамгийн олон малтай сумаар Эрдэнэдалай сум 519969 толгой, Сайнцагаан сум 375810 толгой, Өлзийт сум 328739 толгой, Адаацаг сум 282135 толгой, Хулд сум 273083 толгой мал тоолуулж тэргүүлсэн байна./Зураг.12/ Эрдэнэдалай сум улсын хэмжээнд малын тоогоор зургаадугаар байранд орсон байна. Өлзийт сум улсын хэмжээнд тэмээний тоогоор тавдугаар байранд, Эрдэнэдалай сум улсын хэмжээнд ямааны тоогоор хоёрдугаар байранд тус тус орсон байна. /Зураг13/

Хүснэгт 12. 2022 оны жилийн эцсийн малын тоо, сумдаар, төрлөөр

Сумд	Бүгд	Үүнээс				
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Сайнцагаан	375 810	994	20 632	6 596	178 293	169 295
Адаацаг	282 135	807	15 989	7 236	137 312	120 791
Баянжаргалан	126 953	260	6 528	3 579	68 189	48 397
Говь-Угтаал	176 536	557	7 845	3 418	91 095	73 621
Гурвансайхан	254 889	2 428	9 854	4 846	133 962	103 799
Дэлгэрхангай	185 831	4 577	9 195	2 355	68 363	101 341
Дэлгэрцогт	176 286	639	7 226	4 444	83 426	80 551
Дэрэн	253 572	1 650	11 833	4 785	125 902	109 402
Луус	183 514	715	11 228	5 292	82 991	83 288
Өлзийт	328 739	15 467	13 349	3 170	140 560	156 193
Өндөршил	166 089	3 351	13 346	4 581	79 855	64 956
Сайхан-овоо	182 467	743	8 690	3 229	80 241	89 564
Хулд	273 083	7 059	13 630	3 210	125 923	123 261
Цагаандэлгэр	140 497	652	8 862	3 414	73 104	54 465
Эрдэнэдалай	519 969	1 239	24 860	14 380	254 999	224 491
<b>Дүн</b>	<b>3 626 370</b>	<b>41 138</b>	<b>183 067</b>	<b>74 535</b>	<b>1 724 215</b>	<b>1 603 415</b>




Зураг .13. Нийт малын тоо, сумдаар, 2022 оны жилийн эцсийн байдлаар



2022 оны эцэст 15 сумын нийт малын тоо өсч, үүнээс Дэлгэрцогт сум 24.5 хувь, Сайхан-Овоо сум 23.6 хувь, Дэлгэрхангай сум 20.6 хувь, Дэрэн сум 19.1 хувь, Луус сум 18.2 хувь ба бусад сумдад 15.1-7.0.6 хувиар тус тус өссөн байна.

/Зураг.14 Малын тооны өөрчлөлт/




Нийт мал сүрэгт хонь 47.6 хувь, ямаа 44.2 хувь, адуу 5.0 хувь, үхэр 2.1 хувь, тэмээ 1.1 хувийг эзэлж байна. Энэ оныг 1990 онтой харьцуулж үзэхэд нийт сүрэгт эзлэх хонины хувь 10.7 хувиар буурч, ямааны эзлэх хувь 24.4 хувиар өссөн, адууны



эзлэх хувь 3.7 хувиар, үхрийн эзлэх хувь 8.9 хувиар, тэмээний эзлэх хувь 1.0 хувиар тус тус буурсан байна.

Зураг 1.15. Нийт малын тоо сүргийн бүтэц, хувиар



Хүснэгт 13. Нийт сүрэгт малын таван төрлийн эзлэх хувь, жил бүрийн эцсийн байдлаар

Бүгд	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100	100
Тэмээ	1.2	1.1	1.1	1.1	1	1	1	1.1	1.2	1.1
Адуу	4.3	4.3	4.5	4.5	4	4	4	4.4	5	5
Үхэр	1.8	1.9	2	2	2	2	2	2	2.1	2.1
Хонь	46.2	45.8	45.8	47	47	48	48	47.9	48.4	47.6
Ямаа	46.5	46.9	46.6	45.4	46	45	45	44.6	43.3	44.2

Хүснэгт 14. Хамгийн олон мал тоолуулсан сум, баг

### Нийт малын тоогоор, толгой

Сумын түвшинд	Тоо	Багийн түвшинд	тоо
Эрдэнэдалай	519969	Эрдэнэдалай 5-р баг, Цагаан-Овоо	107382
Сайнцагаан	375810	Эрдэнэдалай 4-р баг, Рашаант	104362
Өлзийт	328739	Сайнцагаан сум 3-р баг, Далай	87246
Адаацаг	282135	Адаацаг сум 4-р баг, Сүм	85983
Хулд	273083	Өлзийт сум 2-р баг, Буянт 2	85617

**Адууны тоогоор, толгой**

Сумын түвшинд	Тоо	Багийн түвшинд	тоо	
Эрдэнэдалай	24860	Өндөршил	2-р баг, Талын нар	6623
Сайнцагаан	20632	Өндөршил	1-р баг, Цог	6435
Адаацаг	15989	Сайнцагаан	2-р баг, Тэвш	6072
Хулд	13630	Адаацаг	4-р баг, Сүм	5643
Өлзийт	13349	Эрдэнэдалай	4-р баг, Рашаант	5161

**Үхрийн тоогоор, толгой**

Сумын түвшинд	тоо	Багийн түвшинд	тоо	
Эрдэнэдалай	14380	Эрдэнэдалай	4-р баг, Рашаант	3286
Адаацаг	7236	Эрдэнэдалай	5-р баг, Цагаан-Овоо	2601
Сайнцагаан	6596	Өндөршил	2-р баг, Талын нар	2429
Луус	5292	Эрдэнэдалай	6-р баг, Сангийн далай	2336
Гурвансайхан	4846	Эрдэнэдалай	2-р баг, Өнгөт	2251

**Тэмээний тоогоор, толгой**

Сумын түвшинд	тоо	Багийн түвшинд	тоо	
Өлзийт	15467	Хулд	2-р баг, Олдох	6070
Хулд	7059	Өлзийт	2-р баг, Буянт 2	4394
Дэлгэрхангай	4577	Өлзийт	3-р баг, Тагт	3275
Өндөршил	3351	Өлзийт	5-р баг, Дэрт 2	2888
Гурвансайхан	2428	Өлзийт	1-р баг, Буянт 1	2864

**Хонины тоогоор, толгой**

Сумын түвшинд	тоо	Багийн түвшинд	тоо	
Эрдэнэдалай	254999	Эрдэнэдалай сум	5-р баг, Цагаан-Овоо	56995
Сайнцагаан	178293	Эрдэнэдалай сум	4-р баг, Рашаант	54136
Өлзийт	140560	Сайнцагаан сум	2-р баг, Тэвш	43167
Адаацаг	137312	Адаацаг сум	4-р баг, Сүм	42456
Гурвансайхан	133962	Сайнцагаан сум	3-р баг, Далай	42316

**Ямааны тоогоор, толгой**

сумын түвшинд	тоо	Багийн түвшинд	тоо	
Эрдэнэдалай	224491	Эрдэнэдалай сум	5-р баг, Цагаан-Овоо	42492
Сайнцагаан	169295	Эрдэнэдалай сум	4-р баг, Рашаант	41577
Өлзийт	156193	Эрдэнэдалай сум	2-р баг, Өнгөт	39716
Хулд	123261	Сайнцагаан сум	3-р баг, Далай	38649
Адаацаг	120791	Өлзийт сум	2-р баг, Буянт 2	38603

**3.2 Хээлтэгч малын тоо**



Хүснэгт 15. Хээлтэгч мал, 5-н төрлөөр, мянган толгой, жил бүрийн эцсийн байдлаар

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2022/2021	
										хувь	зөрүү
Ингэ	10.9	12.2	13	14.3	15.4	16.3	16.5	16.8	17.5	104.2	0.3
Гүү	31.3	37.6	43.1	51.8	56.6	61.4	61.4	62.5	70.2	112.3	1.1
Үнээ	17.8	21.2	24.5	29.6	30.6	32.9	31.8	32.8	33.9	103.4	1
